

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭР ДЭХ
“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК-ИЙН МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ
БИЧИЛ ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/РЕГИСТРИЙН ДУГААР: 6247814/

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

_____ /Г.ЭНХМӨНХ /

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ
ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН:

_____ /П.ШИНЭЦЭЦЭГ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

_____ /Б.АСХАР/

БОЛОВСРУУЛСАН:

“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК-ИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ:

_____ /Г.АНХБАТ/

Улаанбаатар хот

2022 он

“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК

МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ ҮЙЛДВЭР

УЛААНБААТАР ХОТЫН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р
ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ
“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

1. Төслийн танилцуулга	4
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны зорилт	5
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, тэдгээрийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	5
a. Агаарын чанар.....	5
b. Физик бохирдол, хог хаягдал.....	6
c. Гадаргын болон газрын доорх ус	6
d. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч.....	6
e. Ургамлын нөмрөг	7
f. Нийгэм, эдийн засаг	7
g. Бусад	7
4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
5. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10
6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	11
7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11
a. Хог хаягдал ачуулах, тээвэрлэх үйл явц.....	11
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	12
9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	13
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	14

1. Төслийн танилцуулга

Төслийн нэр: “Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх”

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Талын метал нунтаг” ХХК

Регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар: 6247814, 9011713027

Төсөл хэрэгжүүлэгч хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА 1 гудамж, 9 тоот

Хариуцсан ажилтны нэр, утас: Г.Анхбат, 89078935

“Талын метал нунтаг” ХХК-нь өөрийн хэрэгжүүлж буй металл боловсруулах бичил үйлдвэр байгуулах төсөлдөө Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журмын 3 дугаар зүйл, холбогдох аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн эрх бүхий байгууллага “ЖЭМР” ХХК-аар хийлгэсэн болно.

“Талын метал нунтаг” ХХК нь “Степпе Линк” ХХК-тай хамтран 2020 оны 3 дугаар сараас эхлэн үйлдвэрийн барилгын гадна тохижилт, зам талбайн ажлыг нийт 199,143,080 төгрөгөөр гүйцэтгүүлж дууссан. Үйлдвэрийн барилга болон оффисын барилгын ажил бүрэн дуусаж улсын комисс ажиллуулж хүлээлгэж өгсөн.

Монголын анхны нунтаг төмөрлөгийн үйлдвэр нь 2022 оны 04 дүгэр сарын 11 өдөр нээлтээ хийсэн.

Үйлдвэр нь экспортод чиглэсэн, дэвшилтэт технологид суурилсан байгууламж бөгөөд катодын зэс болон хоёдогч эх үүсвэрийн зэсийг боловсруулж, нэмүү үнэ цэн шингэсэн нунтаг төмөрлөг үйлдвэрлэж байна. Компани нь бүтээгдэхүүнээ экспортлохоос гадна нунтаг төмөрлөгт суурилсан орчин үеийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийг дотоодод үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна.

Бүх төрлийн нунтаг металлд физик, химийн иж бүрэн шинжилгээ хийж гүйцэтгэх Монголын анхны лаборатори үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Лабораторийн шинжилгээний орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг ХБНГУ болон АНУ-аас худалдан авч, суурилуулсан.

Лаборатори нь цаашид үйлдвэрийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс гадна автомашины жижиг эд ангийг бага хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой.

2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны зорилт

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тухайн жилээр тооцон тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт зэргийг удирдлага болголоо.

Энэхүү төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага тул цаашид дараах үйл ажиллагааг анхаарч ажиллана. Үүнд:

- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгох;
- ✓ Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх, устгах журмыг үйл ажиллагааныхаа турш баримтлах;
- ✓ Орчны тохижилт, эмх цэгцтэй байдлыг үйл ажиллагааны турш мөрдөх;
- ✓ Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах;
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны бүрдэл хэсгүүдийг тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх;
- ✓ Авто машины тос масло асгарч, гоожин тухайн орчинд бохирдол учруулж болзошгүй тул хяналт тавьж ажиллах;

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, тэдгээрийг бууруулах, арилгах арга хэмжээ

Төслийн байгаль орчны үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд болон нийгмийн байдалд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, арга хэмжээг энэ бүлэгт тусгасан.

а. Агаарын чанар

- Агаарын тухай хуулийн 9-р зүйлд заасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- Тоос, хүхрийн хүчил, азотын давхар ислийн хяналтын хэмжилтийг БОХШХ-ийн дагуу тогтмол хийж, хяналт тавин ажиллана.
- Бүх техникийг үзлэгт тогтмол оруулна.
- Техникийн болон ХАБЭА шаардлагыг мөрдөж ажиллах талаар үйлдвэрийн инженер техникийн ажилтнууд болон жолооч нарт тодорхой давтамжтай сургалт явуулна.

- Хийн хаягдлыг сорох төхөөрөмжийн фильтерийг тогтмол хугацаанд сольж ашиглана.

б. Физик бохирдол, хог хаягдал

- Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангана.
- Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах зориулалтын хогийн цэгт хуримтлуулж гэрээт байгууллагаар хуваарийн дагуу ачуулна. Үйлдвэрийн хог хаягдлыг мөн зориулалтын саванд хадгалж, зарим хаягдлыг тухайлбал усыг бүтэн циклээр дахин ашиглана. Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг тус тусад нь ангилан ялгаж, үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэж ачилт, устгалыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх, устгах журмыг үйл ажиллагааныхаа турш мөрдөж ажиллах;
- Ангилан ялгасан хог хаягдлыг /цаас, шил, хуванцар гэх мэт/ дахин боловсруулах үйлдвэрт тушаана.
- Баянгол дүүргийн Шинэ өргөө ОНӨААТҮГ-тай байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу сар бүр ачилт хийлгэж, төлбөрийг хугацаанд нь төлнө.
- Ажиллагсдын амрах байр /тамхи татах цэг/ болон ажлын байрны ойролцоо боломжтой бүх газруудад хог хаягдлыг ялган ангилах хогийн сав байршуулна. Тухайлбал:
 - ✓ Улбар шар – бүх төрлийн хуванцар хог хаягдал
 - ✓ Ногоон – лааз, шил
 - ✓ Хөх – бичгийн цаасны хаягдал
 - ✓ Хар – бусад хог хаягдал г.м.

с. Гадаргын болон газрын доорх ус

- Үйлдвэр нь төвийн нэгдсэн цэвэр усны шугамд холбогдсон учраас үйлдвэр лүү холбогдсон шугам хоолойд тоолуур тавих, засвар үйлчилгээг тогтмол хийх, тоолуурын заалтыг сар бүр бичиж, фото зургаар баримтжуулан УСҮГ-тай байгуулсан гэрээний дагуу сар бүр төлбөрийг төлнө.
- Үйлдвэр аж ахуйн нэгжээс гарч байгаа бохир усны найрлага нь хотын бохир усны шугамд нийлүүлэгдэх үед Дэд бүтцийн хөгжлийн сайд, Байгаль орчны сайд, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайдын хамтарсан а/11/05/А/18 тоот тушаалаар батлагдсан усны найрлагын зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн байвал бохирдуулагч нэмэгдэл тарифаар төлөх зарчмыг баримтлан төлбөр төлнө.
- Унд ахуй болон үйлдвэрт хэрэглэдэг уснаас тогтмол шинжилгээ авч итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлнэ.

д. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч

- Ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу олон наст ургамал, мод сөөг тарих талбайн хөрсийг бордох, үржил шимийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- Шатахуун, тос тосолгооны материал үйлдвэрийн хашааны дотор болон гадна эзэмшлийн талбайн бүсийн зам талбай, хөрсөнд асгарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг яаралтай авна.

- Жил бүр хөрс хамгаалах арга хэмжээг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний дагуу хэрэгжүүлнэ.
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6, 7-р заалтуудыг үйл ажиллагааныхаа турш мөрдөж ажиллана.

е. Ургамлын нөмрөг

- Газрын тухай хуулийн 6-р бүлгийн 56.6-д заасны дагуу эзэмшилд авсан газрынхаа 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж бий болгоно.
- Хашааны баруун талын мод тарихаар төлөвлөж буй хэсэгт мод сөөг, бутлаг ургамал тарих, олон наст ургамлаар зүлэгжүүлэх, гадна талбайн тохижилтыг сайжруулж өнгө үзэмж бий болгох арчилгаа, тордлогоо хийх ажлыг шат дараатай авч хэрэгжүүлнэ.

ф. Нийгэм, эдийн засаг

- Улс, орон нутагт төлөх татвар, хураамж, төлбөрийг цаг хугацаанд нь төлнө.
- Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс ажил эрхлэлтийн талаарх мэдээллийг авч боломжит ажлын байранд шаардлага хангаж буй иргэдийг ажлын байраар хангах чиглэлд хамтарч ажиллахыг эрмэлзэнэ.
- Хороо, дүүргээс зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцож, шаардлагатай тохиолдолд дэмжлэг тусалцаа үзүүлж ажиллана.

г. Бусад

- Шаардлагатай тохиолдолд Байгаль орчны аудитын үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан хуулийн этгээдтэй экологийн хариуцлагын гэрээ байгуулж байгаль орчны аудит хийлгэнэ.
- Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааг 5 жил тутамд хийлгэнэ.
- Тус үйлдвэрт зэс хайлуулах бортого цэвэрлэхэд ашиглагдах баллонтой азотын хий нь ажлын байрны агаар орчинд болон ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул тээвэрлэх, ашиглах, хадгалах явцдаа аюулгүй ажиллагааны горимыг чанд мөрдөж ажиллана.

4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гал болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын чанар							
SO2, NO2, нийт тоосны хэмжээ стандартаас хэтрэх	Бохир хий сорох төхөөрөмж байршуулах, ажилчдыг сургалтад хамруулах	Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА.1-9 тоот	ХАБЭА-н төсөвт суулгасан зардлаар		Жилд нэг удаа	Агаарын тухай хууль, Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам: MNS 0017-2-3-16:1988 Агаарын чанарын MNS 4585:2016 стандарт	
Техникийн аюулгүй ажиллагааг мөрдөхгүйгээс үүсэх сөрөг нөлөөлөл							
Зам талбайгаас тоосжилт үүсэх			Гадна талбайг зүлэгжүүлэх, услах	Үйл ажиллагааны зардлаар			Тухай бүр
Машин техникийн утааг			Сэрээт өргөгч зэрэг машин техникийг тогтмол үзлэгт оруулах	Үйл ажиллагааны зардлаар			Жилд нэг удаа
Хийн хаягдлыг сорох төхөөрөмжийн фильтр муудах	Фильтерийг сорох төхөөрөмжийн горимын дагуу солих		Үйл ажиллагааны зардлаар		Тухай бүр		
2. Физик бохирдол, хог хаягдал							
Ажилчдад физик бохирдлын улмаас эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл үүсэх	Ажилчдыг эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах	Үйлдвэрийн талбайд	Үйл ажиллагааны зардлаар		Жилд нэг удаа	ХАБЭА шаардлага, үйлдвэрийн дүрэм, журам, заавар	

Ахуйн хог хаягдлаас үүсэх бохирдлын сөрөг нөлөөлөл	Ахуйн хаягдлыг гэрээт байгууллагаар зориулалтын цэгт хүргэж устгуулна. Ангилан ялгалт хийсэн дахивар бүтээгдэхүүнийг зохих газарт нь худалдаж борлуулна.		Үйл ажиллагааны зардлаар	Хуваарийн дагуу	MNS5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Ажлын талбайд тээврийн хэрэгслээс тос масло асгарах, гоожих зэргээс хөрс бохирдох	Элс, даавуунд шингээх, spill kit ашиглаж хөрсийг саармагжуулж цэвэрлэх хэрэгслийг талбайд байршуулна	Талбайд нэг ширхэг	800,000₮	жилд нэг удаа	MNS5850:2018 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
3. Гадаргын болон газрын доорх ус					
Төвийн шугамд холбогдсон шугам хоолойн эвдрэлд гэмтэл гарах	Төвийн шугамд холбогдсон шугам хоолойд хяналт тавьж, эвдрэл гэмтлийг тухай бүх засварлах	Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА.1-9 тоот	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны турш	MNS 4943:2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас ус бохирдуулах	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүтэн циклээр явагдах ба бохирдсон усыг дахин ашиглана. Төвийн бохир усны хоолойд үйлдвэрлэлийн ус нийлэхгүй, зөвхөн ахуйн хаягдал үүснэ		Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны турш	
4. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч					
Тоосжилтын сөрөг нөлөөлөл	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу олон наст ургамал, мод сөөг, бутлаг ургамал тарих, талбайн хөрсийг бордох, үржил шимийг нэмэгдүүлэх	Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА.1-9 тоот	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны турш	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6, 7-р заалт
5. Ургамлын нөмрөг					

Тоосжилтын сөрөг нөлөөлөл	Үйл ажиллагаа явуулж буй газрынхаа 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж бий болгох	Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА.1-9 тоот	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны турш	Газрын тухай хуулийн 6 дугаар бүлгийн 56.6 дахь заалт
Нийт дүн			800,000₮		

5. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зориулалт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Талбай орчим ногоон байгууламж бий болгох, арчилж хамгаалах	Газрын тухай хуулийн 6-р бүлгийн 56.6-д заасны дагуу эзэмшилд авсан газрынхаа 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж бий болгох заалтын дагуу тухайн орчны талхлагдсан газрыг ургамалжуулах, ногоон байгууламж бий болгож, арчлалт хамгаалалт хийнэ	Баянгол дүүргийн 20-р хороо, ДСАА, 1-9 тоот	Үйл ажиллагааны зардлаар	500,000₮	Газрын тухай хуулийн 6 дугаар бүлгийн 56.6 дахь заалт
Орчны тохижилтыг сайжруулах	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	Баянгол дүүрэгт	16	1,500,000₮	
Нийт дүн				2,000,000₮	

6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай нь хүн ам хэт төвлөрсөн, үйлдвэрийн бүсэд байрлах тул түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй.

7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ажилчдын Ахуйн хатуу хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг түр хадгалах цэгт цуглуулж тогтсон хугацаанд тээвэрлэх	Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА.1-9 тоот	50,000₮	12	600,000₮	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, хог хаягдал тээвэрлэх устгах журам
Шингэн хог хаягдал	Гал тогоо болон ажилчдын ариун цэврийн өрөөнөөс гарах бохир ус		Үйл ажиллагааны зардлаар	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг “Мах Маркет” ХХК-ийн төв бохирын худагт 150мм-ийн хэмжээтэй ширмэн бохирын хоолойгоор дамжуулан зайлуулдаг.		Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус	
Нийт					600,000₮		

а. Хог хаягдал ачуулах, тээвэрлэх үйл явц

2020.07.01-ний өдрөөс эхлэн Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ-тай Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ, Баянгол дүүргийн 20-р хорооны Засаг даргатай Тохижилт цэвэрлэгээний гэрээг тус тус байгуулж тухай бүр хог хаягдлаа ачуулж байна. Мөн хог хаягдлын гэрээний дагуу улирал бүр 150,000 төгрөгийг хог ачуулах тээвэрлэх зардалд зарцуулж байна.

8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Шинжилгээний үзүүлэлт	Байршил	Хугацаа ба Давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт аргачлал
Агаар				142.5	
Хүхэрлэг хий(SO ₂), азотын давхар исэл(NO ₂), Нийт тоосонцрын хэмжилт(TST)	Үйлдвэрийн дотор болон гадна талбайд	Жилд нэг удаа 3 цэгээс	1 дээжийн үнэ 32.5	32.5*3=97.5	Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS0017-2-3-16:1988 Агаарын чанар MNS 4585:2016 Дээжлэхдээ: УСТ 0017-2-5-12-1988, ISO 81868 УСТ 0017-2—5-11-1988, MNS 4048:1988, ISO9855:1983, MNS 5002:2000
Физик бохирдол дуу чимээ	Үйлдвэрийн дотор болон гадна талбайд	Жилд нэг удаа 9 цэгт	1 дээжийн үнэ 5.0	5.0*9=45.0	
Ус				150.0	
Ахуйн болон үйлдвэрт хэрэглэх ус	Цэвэр усны шугам	Жилд нэг удаа	1 дээжийн үнэ 50.0	50.0	Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018
Бохир ус	Бохир усны шугам	Жилд нэг удаа	1 дээжийн үнэ 100.0	100.0	MNS 4943:2015, ДБХ-ийн сайд, БО-ны сайд, ЭМХ-ын сайдын хамтарсан а/11/05/А/18 тушаал
Хөрс				235.0	
Хөрсний механик бүрэлдэхүүн химийн үндсэн шинж, Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Co) гэх мэт	Үйлдвэрийн талбайн гадна болон дотор	Жилд нэг удаа гурван цэгээс	1 дээжийн үнэ 35.0	3*35.0=105.0	MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хөрсний нянгийн бохирдол	Хогийн цэг болон оффисын байр орчим	Жилд нэг удаа хоёр цэгээс	1 дээжийн үнэ 30.0	2*30.0=60.0	
Хөрсний цацраг идэвхт бодис	Хашааны гадна талбайд болон хашаан дотор	Жилд нэг удаа хоёр цэгээс	1 дээжийн үнэ 35.0	2*35.0=70.0	
Нийт				527.500₮	

9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төлбөр	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2023 он		
ТЖБОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулах	Дотоод нөөц бололцоогоор	Жил бүр 11-р сарын 1-с өмнө	Захирал	Тухайн жилд сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлыг тусгах
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх		2023 онд	Хуульч	Компанийн зүгээс баримтлах байгаль орчны бодлоготой болох
Жил бүрийн БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын тухай бүрд нь шийдвэрлэж өгөх	ТЖБОМТ-нд тусгагдсан зардал	Жил бүрийн 1,2-р улиралд багтаан	ХАБЭАБО-ны Менежер	Нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах
Ирэх жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	Тухайн жилийн 12 сард	ХАБЭАБО-ны Менежер	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	43,000,000₮	2023 онд	Нягтлан	Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг Баянгол дүүрэгт төлж байна
Нийт	43,000,000₮			

10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах байгууллагууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Нийслэлийн байгаль орчны газар	Тайлагнах мэдээлэл хүргүүлэх	Төслийн талбайд хийсэн ус, хөрс, агаарын чанарын шинжилгээний дүн	Улирал бүр	-	-
“Талын метал нунтаг” ХХК	Уулзалт тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт	2023.11-р сарын 1-ээс өмнө өгөх	Хэрэгжилтийн үйл явцыг танилцуулж, санал авах	Үйлдвэрийн талбайд
Баянгол дүүргийн 20-р хороо	Хуралд танилцуулах, хэлэлцүүлэх	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт, ирэх онд хийх БОМТ	Жил бүрийн 12-р сарын 20-ны дотор	БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөний төсөл дээр санал авч хамтран ажиллах -	Хорооны төв, Дүүрэг БОГ
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг хэвлэмэл болон файл хэлбэрээр			Хянуулах, батлуулах	Улаанбаатар хот, БОАЖЯ

“Талын метал нунтаг” ХХК-нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 4,000,000₮ төсөвлөсөн.

-ооо-